

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалт

Огноо:	2020 оны 12 дугаар сарын 02-ны өдөр
Төслийн дугаар, нэр:	P152343: Дэлхийн банкны санхүүжилттэй Эрчим хүчний төсөл - 2
Тендер шалгаруулалтын дугаар, нэр:	G-NCB-A-9-A: “ЭБЦТС” ТӨХК, “БЗӨБЦТС” ТӨХК-Д САНХҮҮГИЙН СИСТЕМ НИЙЛҮҮЛЖ СУУРИЛУУЛАХ
Тендерийн материал ирүүлэх сүүлийн хугацаа:	2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 14:00 цагт

1. Энэхүү тендерийн урилга нь 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдөр “Бизнесийн Хөгжил” дээр нийтэлсэн Төслийн Худалдан авах ажиллагааны Ерөнхий мэдэгдлийг дагуу зарлагдаж байна.
 2. Монгол улсын Засгийн газар нь Олон улсын хөгжлийн ассоциацийн зээл болон буцалтгүй тусламжийн санхүүжилтээр “Эрчим хүчний төсөл – 2” төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд, энэхүү төслийн хүрээнд G-NCB-A-9-A: “ЭБЦТС” ТӨХК, “БЗӨБЦТС” ТӨХК-Д САНХҮҮГИЙН СИСТЕМ НИЙЛҮҮЛЖ СУУРИЛУУЛАХ ажиллагааг санхүүжүүлнэ.
 3. Эрчим хүчний яам эрх бүхий тендерт оролцогчдоос “ЭБЦТС” ТӨХК, “БЗӨБЦТС” ТӨХК-Д САНХҮҮГИЙН СИСТЕМ НИЙЛҮҮЛЖ СУУРИЛУУЛАХ зорилгоор битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.
 4. Тендер нь Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны зээл болон Олон улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны журам (2011 оны 1 дүгээр сар, 2014 оны 7 дугаар сард шинэчлэн боловсруулсан)-ын Дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалтыг дагуу явуулах бөгөөд Худалдан авалтын журамд тодорхойлсон эрх бүхий бүх тендерт оролцогчдод нээлттэй байна. Мөн Дэлхийн Банкны ашиг сонирхлын зөрчлийн талаарх бодлогыг тодорхойлсон 1.6 ба 1.7-р заалтыг үзнэ үү.
 5. Дотоодын давуу эрх тооцохгүй. Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - **Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 3 жилд (2017, 2018, 2019) гүйцэтгэж дууссан эсхүл гүйцэтгэж байгаа гэрээний жилийн дундаж борлуулалтын доод хэмжээ 570,000,000 (Таван зуун далан сая) төгрөгөөс доошгүй байна
 - **Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** 456,000,000 (Дөрвөн зуун тавин зургаан сая) төгрөгөөс багагүй байна.
 - **Сүүлийн 3 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:**
 - Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудад үндсэн гүйцэтгэгчээр амжилттай ажиллаж дуусгасан 1 (нэг) гэрээтэй байна. Нэг гэрээний нийт үнийн дүнгийн хэмжээ нь 570,000,000 (Таван зуун далан сая) төгрөгөөс доошгүй байна. Гэрээний агуулга ба иж бүрдэл нь нэрлэсэн тендертэй ижил байна.
 - Компани нь 3-аас доошгүй жилийн нэрлэсэн тендертэй ижил санхүүгийн систем боловсруулж, нэвтрүүлж байсан туршлагатай байх
 - Тухайн худалдан авах иж бүрдэл бүхий системийг 3-аас доошгүй байгууллагад нэвтрүүлсэн байх
- Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгээс дэлгэрэнгүй шаардлагыг үзнэ үү.
6. Сонирхсон тендерт оролцогч нь урилгын төгсгөлд заасан Төсөл хэрэгжүүлэх нэгжийн и-мэйл хаягаар хүсэлтээ гаргаж, 100,000 (нэг зуун мянган) төгрөг эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар хураамжийг эргэн үл төлөгдөх нөхцөлтэйгөөр төлсөнөөр тендерийн баримт бичгийг худалдан авч болно. Төлбөрийн данс:

Дансны нэр: Эрчим хүчний төсөл 2

Дансны дугаар: 100900011848

Банкны нэр: Төрийн сан банк.

7. Тендерийг 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 14:00 цагт эсхүл түүнээс өмнө урилгын төгсгөлд заасан хаягаар ирүүлнэ. Хугацаа хоцорсон тендерийг хүлээн авахаас татгалзана.
8. Тендерийн хамт: *11,400,000 (Арван нэгэн сая дөрвөн зуун мянга) төгрөгийн үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.*
9. Тендерийг 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 14:30 цагт доор заасан хаягаар хүрэлцэн ирж, нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдын төлөөллийг байлцуулан нээнэ.

Хаяг: Монгол Улс, 17060, Улаанбаатар хот, ХУД, III хороо, Чингисийн өргөн чөлөө, Засгийн Газрын XIV байр, Эрчим хүчний яамны хурлын танхим

10. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо

Чингисийн өргөн чөлөө-36, Гэгээнтэн оффис, 503 тоот

Эрчим хүчний яамны Эрчим хүчний төсөл-2

Санхүүгийн ажилтан Б.Дэмбэрэл

Утас: +976-77008544; И-мэйл: demberel@esp2.mn